



САНХҮҮГИЙН АУДИТЫН ТАЙЛАН

Баянлиг сумын Засаг даргын Тамгын газрын 2019 оны санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлд хийсэн санхүүгийн тайлангийн аудит

Аудитын код: БНА-2020/23/СТА-ТШЗ

Баянхонгор 2020 он	Тэргүүлэх аудитор: Б.Мөнхбат Утас: 99007576 Цахим хаяг: munkhbatb@audit.gov.mn Аудитын менежер: А.Цээням Утас: 88089024 Цахим хаяг: tseenyama@audit.gov.mn Аудитор: Ж.Өсөхбаяр Утас: 99890393 Цахим хаяг: usuhuu83@yahoo.com Цахим хуудас: www.audit.mn
-----------------------	---

Энэхүү аудитын тайлантай холбоотой нэмэлт мэдээллийг дээрх хаягаар авна уу.

Товчилсон үгийн жагсаалт

УСНББОУС	Улсын Секторын Нягтлан Бодох Бүртгэлийн Олон Улсын Стандарт
АДБОУС	Аудитын Дээд Байгууллагын Олон Улсын Стандарт
АОУС	Аудитын Олон Улсын Стандарт

1. Аудитын гэрчилгээ	3
Аудитын тайлан.....	5
2.1. Оршил	5
2.2. Аудит хийх үндэслэл, зорилго, талуудын хүлээх үүрэг, хариуцлага	5
2.3. Аудитад мөрдсөн бодлого, журам, арга зүй, шалгуур үзүүлэлт	5
2.4. Байгууллагын зорилго, үйл ажиллагаа, хууль, эрх зүйн орчин	5
2.5. Нягтлан бодох бүртгэлийн бодлого, санхүүгийн үйл ажиллагаа болон дотоод хяналттай холбоотой хүчин зүйлсийн үнэлгээ	6
2.6. Төлөвлөлтийн шатанд тодорхойлсон эрсдэл, түүнийг үнэлсэн байдал.....	6
2.7. Материаллаг байдлын суурь сонгосон үндэслэл, тайлбар	6
2.8. Санхүүгийн тайлангийн үзүүлэлтүүд	7
2.10. Төсвийн гүйцэтгэлийн талаарх тайлбар, тодруулга	7
2.11. Аудитаар хэрэгжүүлсэн горим сорил, түүний үр дүн	8
2.12. Дараагийн аудитаар авч үзэх буюу анхаарал татахуйц бусад чухал асуудал	9
2.13. Шилэн дансны мэдээлэл	9
2.14. Өмнөх аудитаар өгсөн акт, албан шаардлага, зөвлөмжийн хэрэгжилт	9
2.15. Дүгнэлтийн хэлбэр, үндэслэл.....	9
3. Менежментийн захидал.....	10
4. Аудит хийгдсэн санхүүгийн тайлан.....	11
4.1 Аудит хийгдсэн санхүүгийн байдлын тайлан	11
4.2 Аудит хийгдсэн санхүүгийн үр дүнгийн тайлан	12
4.3 Аудит хийгдсэн мөнгөн гүйлгээний тайлан	13
4.4 Аудит хийгдсэн цэвэр хөрөнгө/өмчийн өөрчлөлтийн тайлан	15
4.5 Аудит хийгдсэн төсвийн гүйцэтгэлийн тайлан	15

1. Аудитын гэрчилгээ



**БАЯНХОНГОР АЙМАГ ДАХЬ
ТӨРИЙН АУДИТЫН ГАЗАР**

64101 Баянхонгор аймаг,
Баянхонгор сум, Номгон баг
Утас, факс 7044 2584
E-mail: bayankhongor@audit.gov.mn

Согоо.оол, Т.Н № *1/98*

танай _____ -ны № _____ -т

Г Аудитын гэрчилгээ Г

Г БАЯНЛИГ СУМЫН ЗАСАГ Г
ДАРГЫН ТАМГЫН ГАЗРЫН
ДАРГА Г.МӨНХСҮХ ТАНАА Г

Төрийн аудитын тухай хуулийн 15 дугаар зүйлийн 15.1, 18 дугаар зүйлийн 18.2, Төсвийн тухай хуулийн 8 дугаар зүйлийн 8.9.1-т заасны дагуу Баянлиг сумын Засаг даргын Тамгын газрын 2019 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөр дуусвар болсон санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлд санхүүгийн тайлангийн аудит хийв.

Зөрчилгүй санал дүгнэлт

Баянлиг сумын Засаг даргын Тамгын газрын 2019 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөрх санхүүгийн байдал, санхүүгийн үр дүн, цэвэр хөрөнгө/өмчийн өөрчлөлт, мөнгөн гүйлгээ болон төсвийн гүйцэтгэлийн тайланг материаллаг зүйлсийн хувьд Төсвийн тухай хууль, Нягтлан бодох бүртгэлийн тухай хууль, УСНББОУС-д нийцүүлж, Сангийн сайдын баталсан бодлого, журам, зааврын дагуу үнэн, бодитой, шударга илэрхийлсэн тул зөрчилгүй санал дүгнэлт гаргаж байна.

Санал дүгнэлтийн үндэслэл

Төрийн аудитын байгууллага аудит хийхдээ Аудитын дээд байгууллагуудын нийтээр хүлээн зөвшөөрсөн зарчим, стандарт болон Аудитын олон улсын стандартад нийцүүлэн Монгол Улсын Ерөнхий аудиторын баталсан Санхүүгийн тайлангийн аудитын журам, зааврын дагуу гүйцэтгэсэн. Эдгээр нь санхүүгийн тайлан материаллаг буруу илэрхийллээс ангид эсэх талаар үндэслэлтэй баталгаа олж авах зорилгоор аудитыг төлөвлөж, гүйцэтгэхийг шаарддаг.

Аудитаар Баянлиг сумын Засаг даргын Тамгын газрын 2019 оны жилийн эцсийн төсвийн гүйцэтгэл, санхүүгийн тайлан дахь үлдэгдэл, ажил гүйлгээний дүн хэмжээ болон илчлэл тодруулга, тус байгууллагад мөрдөж байгаа нягтлан бодох бүртгэлийн бодлого, бүртгэлийн хөтлөлт, программ хангамж, дотоод хяналтын систем болон удирдлагын хийсэн томоохон тооцооллыг шалгаж, аудитын санал дүгнэлтийг дэмжих нотлох зүйлсийг хангалттай цуглуулсан.

C:\Users\audit_bhr3\Downloads\БНА-2020-23-СТА-ТШЗ_Гэрчилгээ.docx

005020050


Бидний хийсэн аудит тус санхүүгийн тайлан, тодруулгад санал дүгнэлт өгөх хангалттай, зохистой үндэслэлийг бүрдүүлсэн бөгөөд аудитын дүнд үндэслэсэн санал, зөвлөмжийг аудитын тайланд тусгасан болно.

Үүрэг хариуцлага

Төсвийн захирагч нь Төсвийн тухай хуулийн 26 дугаар зүйлийн 26.1-т заасны дагуу тайлант хугацааны санхүүгийн тайлан, тодруулгыг Нягтлан бодох бүртгэлийн болон Улсын секторын нягтлан бодох бүртгэлийн олон улсын стандарт, түүнтэй нийцүүлэн Сангийн сайдын баталсан журам, зааврын дагуу бэлтгэж тайлагнах үүрэгтэй.

Аудитын дээд байгууллагуудын нийтээр хүлээн зөвшөөрсөн зарчим, стандарт болон Аудитын олон улсын стандартын дагуу аудитын хийж, жилийн эцсийн төсвийн гүйцэтгэл, санхүүгийн тайланд санал дүгнэлт өгөх нь төрийн аудитын байгууллагын үүрэг юм.

ДАРГА, ТЭРГҮҮЛЭХ АУДИТОР



Б.МӨНХБАТ

C:\Users\audit_bhr3\Downloads\БНА-2020-23-СТА-ТШЗ_Гэрчилгээ.docx

2.Аудитын тайлан

2.1. Оршил

Баянлиг сумын Засаг даргын Тамгын газрын 2019 оны санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлд хийсэн санхүүгийн тайлангийн аудитын дүн, дүгнэлтийг дарга Г.Мөнхсүх танд танилцуулж байна.

Энэхүү тайланд үйлчлүүлэгчийн санхүү, нягтлан бодох бүртгэл, дотоод хяналтын системд хийсэн үнэлгээний тойм, аудитын явцад илрүүлсэн гол зүйлс, гаргасан шийдлүүд, анхаарал хандуулахуйц асуудал, залруулаагүй материаллаг болон материаллаг бус алдаа зөрчил, тодруулга зэрэг аудитын үр дүн, аудитын дүгнэлтийн хэлбэр, түүний үндэслэлийн талаар тус тус хураангуйлан тэмдэглэв.

Аудитын дүнд үндэслэсэн үйлчлүүлэгчийн нягтлан бодох бүртгэл, тайлагнал, дотоод хяналтын системийг боловсронгуй болгох зөвлөмжийг Менежментийн захидалд тусгасан болно.

2.2. Аудит хийх үндэслэл, зорилго, талуудын хүлээх үүрэг, хариуцлага

Бид Төрийн аудитын тухай хуулийн 15 дугаар зүйлийн 15.1, 15.2, 18 дугаар зүйлийн 18.2, Төсвийн тухай хуулийн 8 дугаар зүйлийн 8.9.1-д заасны дагуу Баянлиг сумын Засаг даргын Тамгын газрын 2019 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөр дуусвар болгосон санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлд аудит хийлээ.

Баянлиг сумын Засаг даргын Тамгын газрын 2019 оны санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэл Нягтлан бодох бүртгэлийн тухай хууль болон УСНББОУС, түүнд нийцүүлэн гаргасан төсвийн байгууллагын нягтлан бодох бүртгэлийн бодлого, заавар, журмын дагуу үнэн зөв, шударга илэрхийлэгдсэн эсэхэд дүгнэлт өгөх нь энэхүү аудитын зорилт байв.

Төсвийн шууд захирагч санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлийн тайлангаа Төсвийн тухай хууль болон УСНББОУС, түүнд нийцүүлэн баталсан төсвийн байгууллагын нягтлан бодох бүртгэлийн бодлого, журмын дагуу үнэн зөв, бодитой бэлтгэх үүрэгтэй.

Харин тухайн санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлийг дээрх хууль болон бодлого, журмын дагуу материаллаг алдаагүй, үнэн зөв, шударга илэрхийлсэн эсэхэд дүгнэлт өгөх нь Төрийн аудитын байгууллагын үүрэг юм.

Аудитыг 2020 оны 02 дугаар сарын 13-наас 2020 оны 02 дугаар сарын 15-ны хооронд гүйцэтгэж, аудитын тайланг 2020 оны 02 дугаар сарын 17-ны өдөр эцэслэн баталгаажуулж, төсвийн шууд захирагчид хүргүүлэхээр төлөвлөн, Баянхонгор аймаг дахь Төрийн аудитын газрын аудитор Ж.Өсөхбаяр хариуцаж хэрэгжүүлэв.

Баянлиг сумын Засаг даргын Тамгын газрын 2019 оны санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлийн тайланг Баянхонгор аймаг дахь Төрийн аудитын газарт 2020 оны 01 дүгээр сарын 07-ны өдрийн 1/19 дугаар бүхий албан бичгээр ирүүлсэн байна.

2.3. Аудитад мөрдсөн бодлого, журам, арга зүй, шалгуур үзүүлэлт

АДБОУС, АОУС, нийтээр хүлээн зөвшөөрсөн бусад зарчимд тулгуурласан Монгол Улсын Ерөнхий аудиторовн баталсан Төрийн аудитын байгууллагаас санхүүгийн тайланд аудит хийх журам, төрийн аудитын байгууллагаас санхүүгийн тайлангийн аудитад баримтлах ерөнхий чиглэл, арга зүйг мөрдөн ажиллав.

Дээрх стандарт, зарчим, журамд нийцүүлж аудитын үе шатны ажлыг гүйцэтгэж, холбогдох ажлын баримт материалаар баталгаажуулсан болно.

2.4. Байгууллагын зорилго, үйл ажиллагаа, хууль, эрх зүйн орчин

Баянлиг сумын Засаг даргын Тамгын газрын үйл ажиллагааны эрхэм зорилго нь "Төрийн үйлчилгээ, бодлого шийдвэрийг ард иргэдэд түргэн шуурхай хүргэж тэдний санал

бодлыг үйл ажиллагаандаа тусган хэрэгжүүлэх, төр иргэний харилцааг дээдэлж, иргэдийн эрүүл аюулгүй орчинд ажиллаж амьдрах нөхцөлийг бүрдүүлэх”.

Баянлиг сумын Засаг даргын Тамгын газрын үйл ажиллагааны чиглэлийг дараах байдлаар тодорхойлжээ. Үүнд:

- Төр, эдийн засаг, нийгмийн бодлогын удирдлагын үйл
- Сум, багаас иргэдэд үзүүлж буй төрийн үйлчилгээний чанар хүртээмжийг нэмэгдүүлэх

Тайлант хугацаанд байгууллагын санхүүгийн үйл ажиллагаанд мөрддөг хууль, тогтоомж, бодлого, журамд өөрчлөлт гараагүй байна.

- Төсвийн тухай хууль
- Нягтлан бодох бүртгэлийн тухай хууль
- Төрийн болон орон нутгийн өмчийн тухай хууль
- Төрийн болон орон нутгийн өмчийн хөрөнгөөр бараа, ажил, үйлчилгээ худалдан авах тухай хууль
- Шилэн дансны тухай хууль
- Монгол Улсын 2019 оны Төсвийн тухай хууль
- Шүүхийн шийдвэр гүйцэтгэх тухай хууль
- Монгол Улсын Засаг захиргаа нутаг дэвсгэрийн нэгж түүний удирдлагын тухай хууль

2.5. Нягтлан бодох бүртгэлийн бодлого, санхүүгийн үйл ажиллагаа болон дотоод хяналттай холбоотой хүчин зүйлсийн үнэлгээ

Бид санхүүгийн тайланд материаллаг алдаа байхгүй гэдгийг нягтлах үүднээс үйлчлүүлэгчийн нягтлан бодох бүртгэлийн бодлого, санхүүгийн үйл ажиллагаа, дотоод хяналтыг шаардлагатай гэж үзсэн хэмжээгээр дахин хянасан болно.

Тус Баянлиг сумын Засаг даргын Тамгын газрын мөрдөж байгаа Нягтлан бодох бүртгэлийн бодлогын баримт бичиг нь Сангийн яамнаас хэрэгжүүлж байгаа нягтлан бодох бүртгэлийн бодлого, холбогдох стандарт, хууль тогтоомжтой нийцсэн байна.

Баянлиг сумын Засаг даргын Тамгын газар нь санхүү, нягтлан бодох бүртгэлийн үйл ажиллагаанд "Санхүүгийн тооцоолох групп" ХХК-ийн "Acolous" программ хангамж ашигладаг байна.

Баянлиг сумын Засаг даргын Тамгын газрын дотоод хяналтын эрсдэлийг төлөвлөлтийн үе шатанд дунд гэж үнэлсэн бөгөөд гүйцэтгэлийн шатанд дахин хянахад дотоод хяналт үр нөлөөтэй байна.

2.6. Төлөвлөлтийн шатанд тодорхойлсон эрсдэл, түүнийг үнэлсэн байдал

Аудитаар Баянлиг сумын Засаг даргын Тамгын газрын бэлтгэсэн санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэл нь материаллаг хэмжээний алдаатай илэрхийлэгдээгүй гэсэн үндэслэлтэй нотолгоо олж авахын тулд байгууллагын гадаад дотоод орчин, дотоод хяналтыг судлан, эрсдэлтэй асуудлыг илрүүлж, үнэллээ.

Аудитын төлөвлөлтийн үе шатанд 35 эрсдэлтэй асуудалд горим сорил хэрэгжүүлэхээр төлөвлөж баталгаажуулсан болно.

2.7. Материаллаг байдлын суурь сонгосон үндэслэл, тайлбар

Аудитыг төлөвлөх үе шатны материаллаг байдлыг АДБОУС 1320, АОУС 320-ын дагуу тодорхойлсон бөгөөд материаллаг байдлын суурь үзүүлэлтээр 2019 оны жилийн эцсийн санхүүгийн үр дүнгийн тайлангийн нийт зардлыг сонгож, эрсдэлийн түвшинг дунд гэж үнэлэн материаллаг байдлын хувь хэмжээг 2.0 хувиар тогтоов.

Төлөвлөлтийн үе шатанд сонгосон суурь үзүүлэлтийн дүн 61129.6 мянган төгрөгөөс тооцон 12224.6 мянган төгрөгөөр материаллаг байдлыг тодорхойлж, баталгаажууллаа.

Гүйцэтгэлийн үе шатанд материаллаг байдлын түвшинг 12224.6 мянган төгрөгөөр тооцсон нь улсын төсвөөс санхүүждэг төсөвт байгууллагын хувьд байгууллагын нийт зардлыг суурь үзүүлэлт болгон сонгох нь зохимжтой гэж үзсэнтэй холбоотой юм.

2.8. Санхүүгийн тайлангийн үзүүлэлтүүд

Баянлиг сумын Засаг даргын Тамгын газрын 2019 оны жилийн эцсийн санхүүгийн байдлын тайлангаарх нийт хөрөнгийн дүн өмнөх оноос 58939.7 мянган төгрөгөөр буюу 1.6 хувиар өссөн байна. Өмнөх оны үзүүлэлтээс материаллаг өөрчлөлт гарсан бараа материал, үндсэн хөрөнгийн данс байна.

Хүснэгт 1. Санхүүгийн байдлын тайлангийн үзүүлэлт

Дансны код	Балансын үзүүлэлт	/мянган төгрөг/	
		Эхний үлдэгдэл	Эцсийн үлдэгдэл
1	ЭРГЭЛТИЙН ХӨРӨНГИЙН ДҮН	67,439.73	61,969.29
31	МӨНГӨН ХӨРӨНГӨ	00.00	00.00
311	Кассанд байгаа бэлэн мөнгө	00.00	00.00
33	АВЛАГА	8,076.60	00.00
34	УРЬДЧИЛГАА	00.00	00.00
35	БАРАА МАТЕРИАЛ	59,363.13	61,969.29
2	ЭРГЭЛТИЙН БУС ХӨРӨНГИЙН ДҮН	3,563,440.47	3,627,850.63
39	ҮНДСЭН ХӨРӨНГӨ	3,563,440.47	3,627,850.63
3	НИЙТ ХӨРӨНГИЙН ДҮН III=I+II	3,630,880.19	3,689,819.92
4	НИЙТ ӨР ТӨЛБӨР	00.00	00.00
5	ЦЭВЭР ХӨРӨНГӨ ӨМЧИЙН ДҮН	3,630,880.19	3,689,819.92
51	Засгийн газрын хувь оролцоо	3,630,880.19	3,689,819.92
6	ӨР ТӨЛБӨР, ЦЭВЭР ХӨРӨНГӨ ӨМЧИЙН ДҮН VI=IV+V	3,630,880.19	3,689,819.92

Бараа материалын дансны үлдэгдэл 2606.2 мянган төгрөгөөр өссөн ба сумын ОНХС-ийн хөрөнгөөр 19000.0 мянган төгрөгөөр өвс тэжээл, мод авсныг бүртгэж, өмч хамгаалах байнгын зөвлөлийн шийдвэрээр 22740.8 мянган төгрөгийн эргэлтийн хөрөнгө акталсан зэрэг томоохон өөрчлөлтүүд гарсан байна.

Бараа материалын дансны үлдэгдэлд өмнөх онуудад худалдаж авсан ашиглалтгүй бараа материал байхгүй байна.

Үндсэн хөрөнгө дансны үлдэгдэл өссөн нь тайлант онд төсвийн хөрөнгөөр 6277.5 мянга, үнэ төлбөргүй 315863.1 мянган төгрөгийн үндсэн хөрөнгө нэмэгдэж Сумын Иргэдийн Төлөөлөгчдийн хурлын 2019 оны 16 дугаар тогтоолоор 33071.2 мянган төгрөгийн хөрөнгө акталсантай холбоотой байна.

Засгийн газрын оролцоо дансны үлдэгдэл 3689819.9 мянган төгрөг болж 58939.7 мянган төгрөгөөр өссөн нь хуримтлагдсан үр дүн 58939.7 мянган төгрөгөөр өссөнтэй холбоотой байна.

2.10. Төсвийн гүйцэтгэлийн талаарх тайлбар, тодруулга

Төсвийн тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.1-д заасны дагуу төсвийг төлөвлөх, хэрэгжүүлэх, тайлагнахад эрх бүхий байгууллага, төсвийн шууд захирагч нь энэ хуулийн 5 дугаар зүйлийн 5.1-д заасан төсвийн зарчмыг мөрдлөг болгож, хэрэгжүүлэх үүрэгтэй.

Баянлиг сумын Засаг даргын Тамгын газар нь тайлант онд 600.0 мянган төгрөгийн орлого төвлөрүүлэхээр батлагдсанаас гүйцэтгэлээр 600.0 мянган төгрөгийн орлогыг үндсэн дансанд төвлөрүүлж, төлөвлөгөөг 100.0 хувиар биелүүлсэн байна.

Хүснэгт 2. Төсөвт байгууллагын өөрийн орлого

/мянган төгрөг/

Орлогын төрөл	Төлөвлөгөө	Гүйцэтгэл	Зөрүү	Хувь
Туслах үйл ажиллагааны орлогоор	600.0	600.0	0.0	100.0
Нийт дүн	600.0	600.0	0.0	100.0

Тайлант онд Төсвийн шууд захирагчийн хэрэгжүүлэх 70106 кодтой нэг хөтөлбөрт зориулан 310104.2 мянган төгрөгийн төсөв батлагдсан нь урсгал зардалд зарцуулахаар батлагджээ.

Нийт зардлын 309504.2 мянган төгрөгийг орон нутгийн төсвөөс, 600.0 мянган төгрөгийг үндсэн болох туслах үйл ажиллагааны орлогоос санхүүжүүлэхээр төлөвлөжээ.

Батлагдсан төсөв, гүйцэтгэл, түүний хэтрэлт, хэмнэлтийг орлого, зардлын зүйл тус бүрээр харуулсан мэдээллийг энэ тайлангийн 4.5-д харуулав.

Тайлант онд орон нутгийн төсвөөс 309096.2 мянган төгрөгийн санхүүжилт авч туслах үйл ажиллагааны орлогоос орох 600.0 мянган төгрөгийг бүрэн төвлөрүүлсэн байна.

Урсгал зардлын гүйцэтгэлийг төлөвлөлттэй харьцуулан авч үзэхэд тайлант онд Санхүүгийн албаны даргын орон тоо дутуу Татварын байцаагчаар хавсран гүйцэтгүүлж байсантай холбоотой цалингийн зардал төлөвлөснөөс 1136.6 мянган төгрөгөөр хэмнэгдсэн нь голлох нөлөөг үзүүлж байна.

Төсвийн нийт зардлын гүйцэтгэл 308665.7 мянган төгрөг буюу 99.8 хувьтай байгаа нь орон нутгийн төсвөөс 309096.2 мянган төгрөгийн санхүүжилт авч урсгал үйл ажиллагааны зарцуулж 1030.5 мянган төгрөг хэмнэгдэн төвлөрүүлсэнтэй холбоотой байна.

Нэмэлт төсөв: Нэмэлт төсвийн дансаар тайлант онд хүүхэд хамгааллын хамтарсан багийн санхүүжилт 1500.0 мянга, тенерийн баримт бичгийн үнэ 510.0 мянга өмнөх онд нэмэлт санхүүжилтийн данснаас төвлөрүүлсэн давсан орлого 6620.0 мянга, тайлант оны давсан орлого 12280.0 мянган төгрөг төвлөрүүлж, хүүхэд хамгааллын хамтарсан багийн санхүүжилт 1500.0 мянган төгрөгийн санхүүжилтийг хүүхэд хамгааллын хамтарсан багийн үйл ажиллагааны зардалд зарцуулан 10760.0 мянган төгрөгийн байгууллагын хамт олны хурлаар хэлэлцүүлэн зарцуулж 20.0 мянган төгрөг төвлөрүүлсэн байна.

2.11. Аудитаар хэрэгжүүлсэн горим сорил, түүний үр дүн

Аудитыг төлөвлөх үе шатанд тогтоосон 35 эрсдэл, гүйцэтгэх үе шатанд 26 эрсдэл тодорхойлж нийт 26 горим сорил хэрэгжүүллээ.

Аудитаар нийт 258179.0 мянган төгрөгийн алдаа, зөрчил илэрснээс, 3000.0 мянган төгрөгийн зөрчилд акт тогтоож, 250575.0 мянган төгрөгийн зөрчлийг арилгах албан шаардлага өгч, 4604.0 мянган төгрөгийн алдаа зөрчлийг арилгах, давтан гаргахгүй байх зөвлөмж өглөө.

Аудитаар дараах 258179.0 мянган төгрөгийн залруулагдаагүй алдаа, зөрчил илэрснээс 3000.0 мянган төгрөгийн зөрчилд төлбөрийн акт тогтоож, 250575.0 мянган төгрөгийн зөрчилд албан шаардлага өглөө. Үүнд:

1. 1. Татварын байцаагчийн үр дүнгийн гурвалсан гэрээнд Төсвийн тухай хуулийн 46.1 дэх заалтыг "Төсвийн захирагчид туслах үйл ажиллагааны ашиг, төсвийн зарлагын хэмнэлт болон төсвийн захирагчийн үр дүнгийн гэрээний урамшууллыг төсвийн урамшуулал болгон тус тус олгож болно" гэж хуулийн заалтыг гэрээнд буруу тусгасан байхад 2019 онд тус байцаагчийн 2017, 2018 оны үр дүнгийн гэрээний хугацаа дууссан, татварын байцаагч 2019 оны 4 дүгээр сард тэтгэвэрт гарсан байхад 11 дүгээр сард үр дүнгийн гэрээний урамшуулалд Баянлиг сумын Засаг даргын Тамгын газрын төсвөөс 1.0 сая төгрөг олгосон байна.

Мөн байгууллагын урсгал үйл ажиллагааны бусад бараа үйлчилгээний зардлаас 2.0 сая төгрөгийн үнэ бүхий мотоцикль худалдан авч Хилийн цэргийн 0166 дугаар ангид өгсөн байна.

Энэ нь Төсвийн тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.6.6 дахь “тухайн шатны төсвөөс санхүүжүүлэхээр хуулиар тогтоосон чиг үүргийг зөвхөн тухайн шатны төсвийн санхүүжилтээр хэрэгжүүлэх”, 25 дугаар зүйлийн 25.10. “Төрийн болон орон нутгийн өмчит хуулийн этгээд хандив, тусламж өгөхийг хориглоно” гэсэн заалтыг тус тус зөрчсөн, “Үнэн зөв байдал” гэсэн батламж мэдэгдлийг хангахгүй байна.

Шийдвэрлэсэн нь: Төлбөрийн акт тогтоохоор шийдвэрлэв.

2. Тус байгууллагын санхүүгийн тайланд бүртгэлтэй автомашинуудаас 2015 онд бүртгэсэн 26.3 сая төгрөгийн үнэ бүхий 81-29ӨВР дугаартай Ланд-80 автомашин, 2018 онд бүртгэсэн 29.8 сая төгрөгийн 53-57УБН дугаартай бохирын автомашин, 2019 онд аймгийн ЗД-ын ангилагдаагүй зардал болон сумын ОНХС-ийн хөрөнгөөр бэлтгэсэн 46,0 сая төгрөгийн 72-27 УБА дугаартай Ланд-105 , 32,8 сая төгрөгийн үнэтэй 51-69 БНХ дугаартай хог тээврийн зориулалттай автомашин, нийт 135.0 сая төгрөгийн 4 автомашины тээврийн хэрэгслийн гэрчилгээ нь бэлтгэн нийлүүлэгчийн нэр дээр бүртгэлтэй тус байгууллагын эзэмшилд шилжиж ирээгүй байна. Мөн тус байгууллагын хөрөнгөд бүртгэлтэй трактор, мотоцикль, кама маркын хогийн автомашин зэрэг 9 төрлийн 115.6 сая төгрөгийн тээврийн хэрэгсэл нь гэрчилгээ, бичиг баримт огт байхгүй байна.

Энэ нь Авто тээврийн тухай хуулийн 171 дүгээр зүйлийн 171.1 дэх “Монгол Улсад бүртгэлтэй аж ахуйн нэгж, байгууллага, хувь хүн тээврийн хэрэгсэл өмчилж авснаас хойш 72 цагийн дотор, ашиглалтаас хассанаас хойш нэг сарын дотор аймаг, нийслэл дэх авто тээврийн асуудал эрхэлсэн төрийн захиргааны төв байгууллагын харьяа байгууллагад бүртгүүлнэ” гэсэн заалтыг зөрчсөн, “Эрх ба үүрэг”, гэсэн батламж мэдэгдлийг хангахгүй байна.

Шийдвэрлэсэн нь: Албан шаардлага өгөхөөр шийдвэрлэв.

Аудитаар илэрсэн 4604.0 мянган төгрөгийн алдаа, зөрчилд зөвлөмж өгч, менежментийн захидалд тусгалаа.

2.12. Дараагийн аудитаар авч үзэх буюу анхаарал татахуйц бусад чухал асуудал

Анхаарал татахуйц асуудал байхгүй байна.

2.13. Шилэн дансны мэдээлэл

Баянлиг сумын Засаг даргын Тамгын газар Шилэн дансны тухай хуулийн 6 дугаар зүйлд заасан 133 мэдээллийг хугацаанд нь, 16 мэдээллийг хугацаа хоцроож байршуулсан, 2 мэдээллийг байршуулах хугацаа болоогүй байна.

д/д	Хугацаа	Төрөл	Удаа	Хугацаанд оруулсан	Хугацаа хоцроосон	Хугацаа болоогүй
1	Бүтэн жил	11	11	9		2
2	Хагас жил	4	4	4		
3	Улирал бүр	1	4	4		
4	Сар бүр	3	36	31	5	
5	Тухай бүр	8	96	70	26	
	Нийт	27	151	118	31	2

2.14. Өмнөх аудитаар өгсөн акт, албан шаардлага, зөвлөмжийн хэрэгжилт

Өмнөх оны санхүүгийн тайлангийн аудитаар акт, албан шаардлага, зөвлөмж өгөгдөөгүй байна.

2.15. Дүгнэлтийн хэлбэр, үндэслэл

Бид Баянлиг сумын Засаг даргын Тамгын газрын 2019 оны санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлийн тайланд аудит хийж, баталгаажуулах ажлыг АДБОУС-ын дагуу, Монгол Улсын холбогдох хууль тогтоомжид нийцүүлэн гүйцэтгэсэн.

“Зөрчилгүй” дүгнэлт

Баянлиг сумын Засаг даргын Тамгын газрын 2019 оны жилийн эцсийн санхүүгийн байдал, санхүүгийн үр дүн, мөнгөн гүйлгээ, өмчийн өөрчлөлт болон бусад илчлэл тодруулгыг холбогдох хууль, Нягтлан бодох бүртгэлийн тухай хуулийн 4.1.3 дахь заалтын дагуу материаллаг байдлын хувьд үнэн зөв, бодитой илэрхийлсэн эсэхийг Аудитын гэрчилгээнд тодорхой дурдав.

3. Менежментийн захидал

Төрийн аудитын байгууллага санхүүгийн тайлангийн аудит бүрийн төгсгөлд аудитаар илрүүлсэн зүйлсийг нэгтгэсэн менежментийн захидлыг үйлчлүүлэгч, түүний удирдлагад зориулж бэлтгэдэг бөгөөд түүнд санхүү, нягтлан бодох бүртгэл, тайлагналын бодлого, үйл ажиллагаа, дотоод хяналтыг сайжруулах зөвлөмжийг тусгадаг.

Энэхүү менежментийн захидлын агуулга аудитын үр дүн, дүгнэлтээс урган гарсан болно. Санхүүгийн тайлан, бусад илчлэл тодруулгын талаар санал дүгнэлт гаргахад бидний бодлого, горим зориулагдсан.

Энэ нь нягтлан бодох бүртгэлийн бодлого, горимыг зөвхөн аудитыг үр нөлөөтэй гүйцэтгэхэд шаардагдах цар хүрээнд дахин хянасан бөгөөд оршиж буй бүх сул талыг гаргаж ирэх боломжгүй юм.

Тиймээс аудитын тайланд тусгасан зөвлөмж нь аудит хийх үеийн нөхцөл байдлын талаарх бидний үнэлэлт, дүгнэлтийг илэрхийлж байгаа болно.

Харин эдгээр зөвлөмжийг та бидний хамтын ажиллагааны байр сууринаас гаргасан бөгөөд аудитаар өгсөн зөвлөмжийг хүлээн авч, хэрэгжүүлэх нь танай үүрэг хариуцлага юм.

Менежментийн захидалд дурдсан цаашид санхүүгийн тайланд шууд бөгөөд материаллаг хэмжээгээр нөлөөлж болзошгүй тул анхаарвал зохих асуудлыг тэргүүлэх ач холбогдлоор нь эрэмбэлэн үзүүлэв. Үүнд:

1. **Балансын данстай холбоотой асуудал**

- 1.1. **Илрүүлэлт:** Биет бус хөрөнгөд бүртгэлтэй 1754,0 мянган төгрөгийн программ хангамжаас 200,0 мянган төгрөгийн үнэтэй архивын программ, 804,0 мянган төгрөгийн үнэтэй төрийн сангийн хуучин программ нь ашиглалтгүй байна.
- 1.2. **Эрсдэл:** Ашиглалтгүй биет бус хөрөнгө санхүүгийн тайланд бүртгэлтэй байх
- 1.3. **Өгсөн зөвлөмж:** Дансанд бүртгэлтэй программуудыг цаашид ашиглах боломжтой эсэхийг тодруулж, холбогдох арга хэмжээг авч ажиллах
- 1.4. **Байгууллагаас өгсөн хариу тайлбар:** Цаашид алдааг давтан гаргахгүй зөвлөмжийг хэрэгжүүлж ажиллана.

2. **Балансын данстай холбоотой асуудал**

- 2.1 **Илрүүлэлт:**Тус байгууллагын нягтлан бодох бүртгэлийн программ хөрөнгийн бүртгэлд бүртгэлгүй байгаа нь Нягтлан бодох бүртгэлийн тухай хуулийн 14 дүгээр зүйлийн 14.4.2 дахь " Нягтлан бодох бүртгэлд бүх хөрөнгө, хөрөнгө оруулалт, авлагыг заавал бүртгэнэ."гэсэн заалтыг зөрчсөн байна.
- 2.2. **Эрсдэл:** хөрөнгө үрэгдэх, эрсдэх
- 2.3 **Өгсөн зөвлөмж:** Нягтлан бодох бүртгэлийн санхүүгийн программыг үнэлж бүртгэлд тусгах
- 2.4 **Байгууллагаас өгсөн хариу, тайлбар:**Аудитаар илэрсэн алдааг хүлээн зөвшөөрч байна, зөвлөмжийг хэрэгжүүлж ажиллана.

3. **Балансын данстай холбоотой асуудал**

- 3.1 **Илрүүлэлт:** Сумын ЗДТГ-ын хөрөнгөнд бүртгэлтэй халаалтын уурын зуухыг Орон нутгийн өмчийн эд хөрөнгийн түрээсийн гэрээгээр аж ахуйн нэгжтэй гэрээ байгуулан жилд 4.2 сая төгрөг төвлөрүүлэх гэрээтэй ч ЗДТГ-ын ТБӨ-ын орлогыг 600.0 мянган төгрөгөөр төлөвлөж давсан 3.6 сая төгрөгийг нэмэлт санхүүжилтийн дансанд төвлөрүүлэн зарцуулсан байна.
Энэ нь Сангийн сайдын 2019 оны 74 дүгээр тушаалаар батлагдсан "Төсвийн зарлагын хэмнэлт, үндсэн үйл ажиллагааны нэмэлт орлогыг зарцуулах, тайлагнах, нягтлан бодох бүртгэлд тусгах, хяналт тавих журам"-ын 3.4.3 дахь "үндсэн үйл ажиллагааны буюу байгууллагын чиг үүргийг хэрэгжүүлэх явцад бий болдог жил бүр давтагдах шинжтэй тогтмол орлогыг төсөвт тусгахгүй орхигдуулахыг хориглоно" гэсэн заалтыг зөрчсөн байна.
- 3.2. **Эрсдэл:** ТБӨ-ыг дутуу төлөвлөж төсөвт тусгаагүй арга хэмжээнд төсвийн хөрөнгө зарцуулж төсвийн үрэлгэн зардал бий болох

- 3.3 **Өгсөн зөвлөмж:** Сангийн сайдын 2019 оны 74 дүгээр тушаалаар батлагдсан "Төсвийн зарлагын хэмнэлт, үндсэн үйл ажиллагааны нэмэлт орлогыг зарцуулах, тайлагнах, нягтлан бодох бүртгэлд тусгах, хяналт тавих журам"-ын 3.4.3 дахь заалтыг хэрэгжүүлж, хөрөнгийн түрээсийн орлогыг бүрэн төлөвлөж, орон нутгийн орлогод төвлөрүүлж ажиллах
- 3.4 **Байгууллагаас өгсөн хариу, тайлбар:** Аудитаар илэрсэн алдааг хүлээн зөвшөөрч байна, зөвлөмжийг хэрэгжүүлж ажиллана.

Дээрх зөвлөмжийн биелэлтийг төрийн аудитын байгууллагад 2020 оны 04 дүгээр сарын 01-ний өдрийн дотор ирүүлнэ үү.

Аудитын явцад бидэнтэй хамтран ажилласан холбогдох ажилтнуудад талархал илэрхийлье.

4. Аудит хийгдсэн санхүүгийн тайлан

4.1 Аудит хийгдсэн санхүүгийн байдлын тайлан

Тайлант хугацаа: 2019 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөр дуусвар болсон тайлан

/Төгрөгөөр/

Дансны код	Балансын үзүүлэлт	Эхний үлдэгдэл	Эцсийн үлдэгдэл
1	ЭРГЭЛТИЙН ХӨРӨНГИЙН ДҮН	67,439,727.73	61,969,290.50
33	АВЛАГА	8,076,595.00	00.00
33100	Ажиллагчидтай холбогдсон авлага	276,595.00	00.00
335	Бусад авлага	7,800,000.00	00.00
3351	Байгууллагаас авах авлага	7,800,000.00	00.00
35	БАРАА МАТЕРИАЛ	59,363,132.73	61,969,290.50
351	Түүхий эд материал	1,374,390.00	708,390.00
35110	Тусгай зориулалттай материал	1,374,390.00	708,390.00
354	Хангамжийн материал	47,047,542.73	50,319,700.50
35410	Бичиг хэргийн материал	2,248,174.00	2,444,614.00
35420	Аж ахуйн материал	29,492,462.00	17,909,020.00
35440	Түлш, шатах тослох материал	00.60	00.00
35470	Бусад хангамжийн материал	15,306,906.13	29,966,066.50
35600	Мал амьтад	10,941,200.00	10,941,200.00
2	ЭРГЭЛТИЙН БУС ХӨРӨНГИЙН ДҮН	3,563,440,466.68	3,627,850,629.82
39	ҮНДСЭН ХӨРӨНГӨ	3,563,440,466.68	3,627,850,629.82
392	Биет хөрөнгө	3,489,523,433.35	3,554,121,096.49
39201	Барилга, байгууламж, орон сууц	3,878,520,980.10	3,909,720,980.10
39202	Хуримтлагдсан элэгдэл	-756,856,049.10	-948,780,213.94
39203	Авто-тээврийн хэрэгсэл	202,623,260.00	270,075,020.00
39204	Хуримтлагдсан элэгдэл	-115,626,899.71	-126,870,819.67
39205	Машин тоног төхөөрөмж (компьютер)	150,801,748.40	277,840,944.90
39206	Хуримтлагдсан элэгдэл	-98,146,360.14	-94,727,474.27
39207	Тавилга, аж ахуйн эд хогшил	110,673,050.96	122,632,239.09
39208	Хуримтлагдсан элэгдэл	-50,233,259.05	-60,243,079.53
39209	Зам, гүүрийн байгууламж	7,193,000.00	13,612,310.00
39210	Хуримтлагдсан элэгдэл	-1,858,191.46	-2,217,841.42
39214	Бусад үндсэн хөрөнгө	197,494,676.00	242,494,676.00
39215	Хуримтлагдсан элэгдэл	-35,062,522.65	-49,415,644.77

393	Биет бус хөрөнгө	73,917,033.33	73,729,533.33
39301	Програм хангамж	1,754,060.00	1,754,060.00
39302	Хуримтлагдсан элэгдэл	-1,708,226.67	-1,895,726.67
39303	Бусад биет бус хөрөнгө	73,871,200.00	73,871,200.00
3	НИЙТ ХӨРӨНГИЙН ДҮН III=I+II	3,630,880,194.41	3,689,819,920.32
5	ЦЭВЭР ХӨРӨНГӨ ӨМЧИЙН ДҮН	3,630,880,194.41	3,689,819,920.32
51	Засгийн газрын хувь оролцоо	3,630,880,194.41	3,689,819,920.32
511	Засгийн газрын оруулсан капитал /Засгийн газрын сан/ орон нутгийн сан	505,387,011.50	505,387,011.50
51101	Өмч: - төрийн	505,387,011.50	505,387,011.50
512	Хуримтлагдсан үр дүн	3,039,656,559.01	3,098,683,036.12
51210	Өмнөх үеийн үр дүн	3,039,656,559.01	3,039,743,310.21
51220	Тайланг үеийн үр дүн	00.00	58,939,725.91
51300	Хөрөнгийн дахин үнэлгээний зөрүү	85,836,623.90	85,749,872.70
6	ӨР ТӨЛБӨР, ЦЭВЭР ХӨРӨНГӨ ӨМЧИЙН ДҮН VI=IV+V	3,630,880,194.41	3,689,819,920.32

4.2 Аудит хийгдсэн санхүүгийн үр дүнгийн тайлан

Тайлант хугацаа: 2019 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөр дуусвар болсон тайлан

Дансны код	Үзүүлэлт	Өмнөх оны гүйцэтгэл	Тайлант оны гүйцэтгэл
1	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ОРЛОГЫН ДҮН (I)	423,021,426.00	670,169,291.00
12	ТАТВАРЫН БУС ОРЛОГО	62,951,850.00	348,793,115.00
120	Нийтлэг татварын бус орлого	62,951,850.00	348,793,115.00
120004	Төсөв байгууллагын өөрийн орлого	62,951,850.00	348,793,115.00
1200042	Туслах үйл ажиллагааны орлогоос санхүүжих	607,860.00	600,000.00
1200045	Үнэ төлбөргүй хүлээн авсан орлого	62,343,990.00	348,193,115.00
13	ТУСЛАМЖ, САНХҮҮЖИЛГИЙН ОРЛОГО	360,069,576.00	321,376,176.00
1310	Улсын төвлөрсөн төсвөөс	13,500,000.00	00.00
131005	Хөрөнгийн санхүүжилт	13,500,000.00	00.00
1311	Нэмэлт санхүүжилтийн орлого	11,050,000.00	12,280,000.00
131104	Дээд шатны төсвийн захирагчийн төсөвт тусгагдсан төсвөөс доод шатны төсвийн захирагчид хуваарилсан хөрөнгө	00.00	1,500,000.00
131105	Төсвийн байгууллагын үндсэн үйл ажиллагааны хүрээнд бий болсон нэмэлт орлого	11,050,000.00	10,780,000.00
1320	Орон нутгийн төсвөөс санхүүжих	332,301,600.00	309,096,176.00
132001	Урсгал үйл ажиллагааны санхүүжилт /орон нутгийн төсөвт байгууллага/	332,301,600.00	309,096,176.00
1340	Нийгмийн даатгалын сангийн төсвөөс санхүүжих	3,217,976.00	00.00
134001	Нийгмийн даатгалын сангаас санхүүжих	3,217,976.00	00.00
2	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ЗАРДЛЫН ДҮН	568,247,761.11	610,260,594.67
21	УРСГАЛ ЗАРДАЛ	568,247,761.11	610,260,594.67
210	БАРАА, АЖИЛ ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ЗАРДАЛ	523,438,748.11	604,377,292.67
2101	Цалин хөлө болон нэмэгдэл урамшил	167,945,283.00	180,224,907.00
210101	Үндсэн цалин	167,945,283.00	180,224,907.00
2102	Ажил олгогчоос нийгмийн даатгалд төлөх шимтгэл	21,199,889.00	22,592,538.00
210201	Тэтгэврийн даатгал	14,470,742.00	15,398,594.00
210202	Тэтгэмжийн даатгал	1,682,286.00	1,799,655.00
210203	ҮОМШӨ-ний даатгал	1,345,829.00	1,439,722.00
210204	Ажилгүйдлийн даатгал	336,458.00	355,261.00
210205	Эрүүл мэндийн даатгал	3,364,574.00	3,599,306.00
2103	Байр ашиглалттай хөлбоотой тогтмол зардал	20,900,651.00	33,185,508.00
210301	Гэрэл, цахилгаан	2,715,451.00	2,375,108.00
210302	Түлш, халаалт	18,045,200.00	30,710,400.00
210303	Цэвэр, бохир ус	140,000.00	100,000.00

**Баянлиг сумын Засаг даргын Тамгын газрын 2019 оны санхүүгийн тайлан,
төсвийн гүйцэтгэлд хийсэн санхүүгийн тайлангийн аудит**

2104	Хангамж, бараа материалын зардал	39,435,869.40	65,278,442.23
210401	Бичиг хэрэг	3,712,850.00	5,809,660.00
210402	Тээвэр, шатахуун	27,946,599.40	26,323,500.60
210403	Шуудан, холбоо, ингериэгийн төлбөр	4,150,520.00	325,000.00
210405	Хог хаягдал зайлуулах, хортон мэрэгчдийн устгал, ариутгал	00.00	300,000.00
210406	Бага үнэгэй, түргэн элэгдэх, ахуйн эд зүйлс	77,100.00	14,786,339.63
210407	Аж ахуйн материал худалдан авах зардал	3,548,800.00	17,733,942.00
2106	Эд хогшил, урсгал засварын зардал	3,144,400.00	4,275,260.00
210601	Багаж, техник, хэрэгсэл	00.00	666,000.00
210604	Урсгал засвар	3,144,400.00	3,609,260.00
2107	Томилолт, зочны зардал	8,050,800.00	8,841,400.00
210701	Гадаад албан томилолт	00.00	1,000,000.00
210702	Дотоод албан томилолт	8,050,800.00	6,875,900.00
210703	Зочин төлөөлөгч хүлээн авах	00.00	965,500.00
2108	Бусдаар гүйцэтгүүлсэн ажил, үйлчилгээний төлбөр, хураамж	3,780,600.00	4,700,780.00
210801	Бусдаар гүйцэтгүүлсэн бусад нийглэг ажил үйлчилгээний төлбөр хураамж	3,780,600.00	4,700,780.00
2109	Бараа үйлчилгээний бусад зардал	258,981,255.71	285,278,457.44
210901	Бараа үйлчилгээний бусад зардал	6,402,600.00	22,666,976.00
210902	Хичээл үйлдвэрлэлийн дадлага хийх	00.00	50,000.00
210903	Үндсэн хөрөнгийн элэгдэл, хөрөгдол	252,578,655.71	256,761,481.44
210904	Найдваргүй авлагын алдагдал	00.00	5,800,000.00
213	УРСГАЛ ШИЛЖҮҮЛЭГ	44,809,013.00	5,883,302.00
2131	Засгийн газрын урсгал шилжүүлэг	34,450,000.00	00.00
213101	Засгийн газрын дотоод шилжүүлэг	34,450,000.00	00.00
2132	Бусад урсгал шилжүүлэг	3,417,976.00	4,832,850.00
213202	Нийгмийн даатгалын тэтгэвэр, тэтгэмж	3,217,976.00	1,123,278.00
213204	Ажил олгогчоос олгох бусад тэтгэмж, урамшуулал	100,000.00	2,109,572.00
213209	Нэг удаагийн тэтгэмж, шагнал урамшуулал	100,000.00	1,600,000.00
2134	Орон нутгийн төсвийн ерөнхийлөн захирагчдад олгох татаас,	321,037.00	1,030,452.00
213403	Төвлөрүүлэх шилжүүлэг	321,037.00	1,030,452.00
2135	Төсвийн захирагчдаас олгосон санхүүжилт, шилжүүлэг	6,620,000.00	20,000.00
213503	Төвлөрүүлэх шилжүүлэг	6,620,000.00	20,000.00
3	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ҮР ДҮН (3)=(1)-(2)	-145,226,335.11	59,908,696.33
225	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ БУС ЗАРДЛЫН ДҮН	284,124,892.36	968,970.42
225001	Үндсэн хөрөнгө худалдсаны гарз	00.00	968,970.42
225007	Хөрөнгийн дахин үнэлгээний зардал	284,124,892.36	00.00
4	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ БУС ҮР ДҮН (4)=(145-225)	-284,124,892.36	-968,970.42
5	НИЙТ ҮР ДҮН (5)=(3)+(4)	-429,351,227.47	58,939,725.91

4.3 Аудит хийгдсэн мөнгөн гүйлгээний тайлан

Тайлант хугацаа: 2019 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөр дуусвар болсон тайлан

/Төгрөгөөр/

Дансны код	Үзүүлэлт	Өмнөх оны гүйцэтгэл	Тайлант оны гүйцэтгэл
1	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ МӨНГӨН ОРЛОГЫН ДҮН (1)	347,177,436.00	323,099,454.00
12	ТАТВАРЫН БУС ОРЛОГО	607,860.00	600,000.00
120	Нийтлэг татварын бус орлого	607,860.00	600,000.00
120004	Төсөв байгууллагын өөрийн орлого	607,860.00	600,000.00
1200042	Туслах үйл ажиллагааны орлогоос санхүүжих	607,860.00	600,000.00
13	ТУСЛАМЖ, САНХҮҮЖИЛТИЙН ОРЛОГО	346,569,576.00	322,499,454.00
1311	Нэмэлт санхүүжилтийн орлого	11,050,000.00	12,280,000.00
131104	Дээд шатны төсвийн захирагчийн төсөвт тусгагдсан төсвөөс доод шатны төсвийн захирагчид хуваарилсан хөрөнгө	00.00	1,500,000.00
131105	Төсвийн байгууллагын үндсэн үйл ажиллагааны хүрээнд бий болсон нэмэлт орлого	11,050,000.00	10,780,000.00

**Баянлиг сумын Засаг даргын Тамгын газрын 2019 оны санхүүгийн тайлан,
төсвийн гүйцэтгэлд хийсэн санхүүгийн тайлангийн аудит**

1320	Орон нутгийн төсвөөс санхүүжих	332,301,600.00	309,096,176.00
132001	Урсгал үйл ажиллагааны санхүүжилт /орон нутгийн төсөвт байгууллага/	332,301,600.00	309,096,176.00
1340	Нийгмийн даатгалын сангийн төсвөөс санхүүжих	3,217,976.00	1,123,278.00
134001	Нийгмийн даатгалын сангаас санхүүжих	3,217,976.00	1,123,278.00
2	НИЙТ ЗАРЛАГА ба ЦЭВЭР ЗЭЭЛИЙН ДҮН (2)	347,177,436.00	318,211,954.00
21	УРСГАЛ ЗАРДАЛ	347,177,436.00	318,211,954.00
210	БАРАА, АЖИЛ ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ЗАРДАЛ	267,591,223.00	312,028,652.00
2101	Цалин хөлс болон нэмэгдэл урамшил	168,388,113.00	180,086,058.00
210101	Үндсэн цалин	168,388,113.00	180,086,058.00
2102	Ажил олгогчоос нийгмийн даатгалд төлөх шимтгэл	20,757,059.00	22,454,792.00
210201	Тэтгэврийн даатгал	20,757,059.00	15,152,704.00
210202	Тэтгэмжийн даатгал	00.00	1,841,300.00
210203	ҮОМШӨ-ний даатгал	00.00	1,439,009.00
210204	Ажилгүйдлийн даатгал	00.00	368,300.00
210205	Эрүүл мэндийн даатгал	00.00	3,653,479.00
2103	Байр ашиглалттай холбоотой тогтмол зардал	22,131,251.00	27,560,508.00
210301	Гэрэл, цахилгаан	2,796,051.00	2,375,108.00
210302	Түлш, халаалт	19,095,200.00	25,085,400.00
210303	Цэвэр, бохир ус	240,000.00	100,000.00
2104	Хангамж, бараа материалын зардал	33,476,000.00	29,671,600.00
210401	Бичиг хэрэг	3,390,880.00	4,207,900.00
210402	Тээвэр, шатахуун	25,835,600.00	24,307,700.00
210403	Шуудан, холбоо, ингэрнэтийн төлбөр	4,150,520.00	356,000.00
210405	Хог хаягдал зайлуулах, хортон мэрэгчдийн устгал, ариутгал	00.00	300,000.00
210406	Бага үнэтэй, түргэн элэгдэх, ахуйн эд зүйлс	99,000.00	500,000.00
2106	Эд хогшил, урсгал засварын зардал	3,157,000.00	5,555,860.00
210601	Багаж, техник, хэрэгсэл	00.00	462,500.00
210604	Урсгал засвар	3,157,000.00	5,093,360.00
2107	Томилолт, зочны зардал	8,050,800.00	10,817,900.00
210701	Гадаад албан томилолт	00.00	1,000,000.00
210702	Дотоод албан томилолт	8,050,800.00	6,875,900.00
210703	Зочин төлөөлөгч хүлээн авах	00.00	2,942,000.00
2108	Бусдаар гүйцэтгүүлсэн ажил, үйлчилгээний төлбөр, хураамж	5,692,600.00	14,025,180.00
210801	Бусдаар гүйцэтгүүлсэн бусад нийтлэг ажил үйлчилгээний төлбөр хураамж	5,692,600.00	12,925,100.00
210806	Мэдээлэл, технологийн үйлчилгээ	00.00	1,100,080.00
2109	Бараа үйлчилгээний бусад зардал	5,938,400.00	21,856,754.00
210901	Бараа үйлчилгээний бусад зардал	5,938,400.00	21,806,754.00
210902	Хичээл үйлдвэрлэлийн дадлага хийх	00.00	50,000.00
213	УРСГАЛ ШИЛЖҮҮЛЭГ	79,586,213.00	6,183,302.00
2131	Засгийн газрын урсгал шилжүүлэг	69,127,200.00	00.00
213101	Засгийн газрын дотоод шилжүүлэг	69,127,200.00	00.00
2132	Бусад урсгал шилжүүлэг	3,517,976.00	5,132,850.00
213202	Нийгмийн даатгалын тэтгэвэр, тэтгэмж	3,217,976.00	1,123,278.00
213209	Нэг удаагийн тэтгэмж, шагнал урамшуулал	300,000.00	4,009,572.00
2134	Орон нутгийн төсвийн ерөнхийлөн захирагчдад олгох татаас, санхүүжилт	321,037.00	1,030,452.00
213403	Төвлөрүүлэх шилжүүлэг	321,037.00	1,030,452.00
2135	Төсвийн захирагчдаас олгосон санхүүжилт, шилжүүлэг	6,620,000.00	20,000.00
213503	Төвлөрүүлэх шилжүүлэг	6,620,000.00	20,000.00
3	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ЦЭВЭР МӨНГӨН ГҮЙЛГЭЭ (3)=(1)-(2)	00.00	4,887,500.00
5	ХӨРӨНГӨ ОРУУЛАЛТЫН МӨНГӨН ЗАРДЛЫН ДҮН (5)	00.00	4,887,500.00
22	ХӨРӨНГИЙН ЗАРДАЛ	00.00	4,887,500.00
2200	Дотоод эх үүсвэрээр	00.00	4,887,500.00
225106	Биет ба биет бус хөрөнгө худалдан авсан зардал	00.00	4,887,500.00
6	ХӨРӨНГӨ ОРУУЛАЛТЫН ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ЦЭВЭР МӨНГӨН ГҮЙЛГЭЭ (6)=(4)-(5)	00.00	-4,887,500.00

4.4 Аудит хийгдсэн цэвэр хөрөнгө/өмчийн өөрчлөлтийн тайлан

Тайлант хугацаа: 2019 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөр дуусвар болсон тайлан

Код	Үзүүлэлт	Засгийн газрын оруулсан капитал	Дахин үнэлгээний нөөц	Хуримтлагдсан дүн	/ төгрөгөөр /
					Засгийн газрын хувь оролцооны нийт дүн
C08	2018 оны 12-р сарын 31-нээрх үлдэгдэл	505,387,011.50	85,836,623.90	3,039,656,559.01	3,630,880,194.41
D01	2018 оны 12-р сарын 31-нээрх үлдэгдэл	505,387,011.50	85,836,623.90	3,039,656,559.01	3,630,880,194.41
D02	Нягтлан бодох бүртгэлийн бодлогын өөрчлөлт	00.00	00.00	86,751.20	86,751.20
D03	Дахин илэрхийлсэн үлдэгдэл	505,387,011.50	85,836,623.90	3,039,743,310.21	3,630,966,945.61
D04	Үндсэн хөрөнгийн дахин үнэлгээний өсөлт, бууралт	00.00	-86,751.20	00.00	-86,751.20
D08	Тайланг үеийн үр дүн	00.00	00.00	58,939,725.91	58,939,725.91
D09	2019 оны 12-р сарын 31-нээрх үлдэгдэл	505,387,011.50	85,749,872.70	3,098,683,036.72	3,689,819,920.92

4.5 Аудит хийгдсэн төсвийн гүйцэтгэлийн тайлан

Тайлант хугацаа: 2019 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөр дуусвар болсон тайлан

Эдийн засгийн ангилал	Үзүүлэлт	Тайлант оны		Зөрүү	Хувь
		Батлагдсан төлөвлөгөө	Гүйцэтгэл		
2	НИЙТ ЗАРЛАГА БА ЦЭВЭР ЗЭЭЛИЙН ДҮН	310,104,200.00	308,665,724.00	1438476.00	99.5
21	УРСГАЛ ЗАРДАЛ	310,104,200.00	308,665,724.00	1438476.00	99.5
210	БАРАА, АЖИЛ ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ЗАРДАЛ	306,094,600.00	304,656,152.00	1438448.00	99.5
2101	Цалин хөлс болон нэмэгдэл урамшил	181,222,700.00	180,086,058.00	1136642.00	99.4
210101	Үндсэн цалин	181,222,700.00	180,086,058.00	1136642.00	99.4
2102	Ажил олгогчоос нийгмийн даатгалд төлөх шимтгэл	22,515,900.00	22,454,792.00	61108.00	99.7
210201	Тэтгэврийн даатгал	15,150,700.00	15,152,704.00	-2004.00	100.0
210202	Тэтгэмжийн даатгал	1,841,300.00	1,841,300.00	0.00	100.0
210203	ҮОМШӨ-ний даатгал	1,473,000.00	1,439,009.00	33991.00	97.7
210204	Ажилгүйдлийн даатгал	368,300.00	368,300.00	0.00	100.0
210205	Эрүүл мэндийн даатгал	3,682,600.00	3,653,479.00	29121.00	99.2
2103	Байр ашиглалттай холбоотой тогтмол зардал	27,562,000.00	27,560,508.00	1492.00	100.0
210301	Гэрэл, цахилгаан	2,376,600.00	2,375,108.00	1492.00	99.9
210302	Түлш, халаалт	25,085,400.00	25,085,400.00	0.00	100.0
210303	Цэвэр, бохир ус	100,000.00	100,000.00	0.00	100.0
2104	Хангамж, бараа материалын зардал	29,674,900.00	29,671,600.00	3300.00	100.0
210401	Бичиг хэрэг	4,068,900.00	4,207,900.00	-139000.00	103.4
210402	Тээвэр, шатахуун	24,307,700.00	24,307,700.00	0.00	100.0
210403	Шуудан, холбоо, ингернэтийн төлбөр	498,300.00	356,000.00	142300.00	71.4
210405	Хог хаягдал зайлуулах, хортон мэрэгчдийн устгал, ариутгал	300,000.00	300,000.00	0.00	100.0
210406	Бага үнэтэй, түргэн элэгдэх, ахуйн эд зүйлс	500,000.00	500,000.00	0.00	100.0
2106	Эд хогшил, урсгал засварын зардал	5,648,400.00	5,648,360.00	40.00	100.0
210601	Багаж, техник, хэрэгсэл	994,000.00	555,000.00	439000.00	55.8
210604	Урсгал засвар	4,654,400.00	5,093,360.00	-438960.00	109.4
2107	Томиллолт, зочны зардал	10,988,600.00	10,817,900.00	170700.00	98.4
210701	Гадаад албан томиллолт	1,000,000.00	1,000,000.00	0.00	100.0
210702	Дотоод албан томиллолт	7,046,600.00	6,875,900.00	170700.00	97.6
210703	Зочин төлөөлөгч хүлээн авах	2,942,000.00	2,942,000.00	0.00	100.0
2108	Бусдаар гүйцэтгүүлсэн ажил, үйлчилгээний төлбөр, хураамж	6,563,600.00	6,560,180.00	3420.00	99.9
210801	Бусдаар гүйцэтгүүлсэн бусад нийтлэг ажил үйлчилгээний төлбөр хураамж	5,462,600.00	5,460,100.00	2500.00	100.0
210806	Мэдээлэл, технологийн үйлчилгээ	1,101,000.00	1,100,080.00	920.00	99.9
2109	Бараа үйлчилгээний бусад зардал	21918500.00	21856754.00	61746.00	99.7
210901	Бараа үйлчилгээний бусад зардал	21,818,500.00	21,806,754.00	11746.00	99.9
210902	Хичээл үйлдвэрлэлийн дадлага хийх	100,000.00	50,000.00	50000.00	50.0
213	УРСГАЛ ШИЛЖҮҮЛЭГ	4,009,600.00	4,009,572.00	28.00	100.0
2132	Бусад урсгал шилжүүлэг	4,009,600.00	4,009,572.00	28.00	100.0
213209	Нэг удаагийн тэтгэмж, шагнал урамшуулал	4,009,600.00	4,009,572.00	28.00	100.0

	ЗАРДЛЫГ САНХҮҮЖҮҮЛЭХ ЭХ ҮҮСВЭР	310,104,200.00	308,665,724.00	1438476.00	99.5
1320	ОРОН НУТГИЙН ТӨСВӨӨС САНХҮҮЖИХ	309,504,200.00	308,065,724.00	1438476.00	99.5
132001	Орон нутгийн төсвөөс	309,504,200.00	308,065,724.00	1438476.00	99.5
120004	ТӨСӨВТ БАЙГУУЛЛАГЫН ҮЙЛ АЖИЛЛАГААНААС	600,000.00	600,000.00	0.00	100.0
1200042	Туслах үйл ажиллагааны орлогоос санхүүжих	600,000.00	600,000.00	0.00	100.0
62	АЖИЛЛАГСАДЫН ТОО	21.00	21.00	0.00	100.0
620001	Удирдах ажилтан	08.00	08.00	0.00	100.0
620002	Гүйцэтгэх ажилтан	08.00	08.00	0.00	100.0
620003	Үйлчлэх ажилтан	05.00	05.00	0.00	100.0

4.6 Аудит хийгдсэн нэмэлт санхүүжилтийн тайлан

Тайлант хугацаа: 2019 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөр дуусвар болсон тайлан

Дансны код	Үзүүлэлт	Өмнөх он	Тайлант он
I	НИЙТ ЗАРЛАГА БА ЦЭВЭР ЗЭЭЛИЙН ДҮН	11050000.00	12,280,000.00
21	УРСГАЛ ЗАРДАЛ	11050000.00	12,280,000.00
210	БАРАА, АЖИЛ ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ЗАРДАЛ	11050000.00	12,280,000.00
2108	Бусдаар гүйцэтгүүлсэн ажил, үйлчилгээний төлбөр, хураамж	11050000.00	12,260,000.00
210801	Бусдаар гүйцэтгүүлсэн бусад нийтлэг ажил үйлчилгээний төлбөр хураамж	11050000.00	12,260,000.00
213	УРСГАЛ ШИЛЖҮҮЛЭГ	0.00	20000.00

АУДИТЫН ТАЙЛАНГ:

Бэлтгэсэн:

АУДИТОР

Ж.ӨСӨХБАЯР

Огноо: 2020.02.17

Анхан шатанд хянасан:

АУДИТЫН МЕНЕЖЕР

А.ЦЭЭНЯМ

Огноо: 2020.02.17

Хоёр дахь шатанд хянасан:

ДАРГА, ТЭРГҮҮЛЭХ АУДИТОР

Б.МӨНХБАТ

Огноо: 2020.02.17

